



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/016/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням
Утас: 51-261665 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанцэнд
Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1203

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд Замын-Үүд хилийн боомтын бүтээн байгуулалтаар бий болсон 107.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 673 дугаар тогтоолоор, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжсэн “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг, Боршоо хилийн боомтуудад хийгдсэн 4.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын даргын А/388, А/562 тоот тушаалуудаар, нийт 112.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Гаалийн байгууллага нь 6,792.9 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 6,743.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 99.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь Засгийн газрын тогтоолоор батлагдсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хойшлуулалт болон ханшийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Гаалийн ерөнхий газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ  Я.САМБУУНЯМ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,431,848.1	39,812,561.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,427,443.8	12,762,269.2
33	АВЛАГА	617,197.3	1,162,182.1
34	УРЬДЧИЛГАА	-	11,609.1
35	БАРАА МАТЕРИАЛ	11,400,371.9	10,528,432.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	14,986,835.1	15,348,068.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	167,868,665.1	285,387,210.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	167,868,665.1	285,387,210.0
39200	Биет хөрөнгө	158,966,721.5	275,067,776.5
39300	Биет бус хөрөнгө	8,901,943.6	10,319,433.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	214,300,513.2	325,199,771.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,911,996.9	11,971,118.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,911,996.9	11,971,118.1
41300	Өглөг	18,911,996.9	11,971,118.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	195,388,516.3	313,228,653.2
51	Засгийн газрын хувь оролцоо	195,388,516.3	313,228,653.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	72,646,284.8	72,665,451.2
51200	Хуримтлагдсан үр дүн	115,960,549.4	233,781,519.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,781,682.1	6,781,682.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	214,300,513.2	325,199,771.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	131,269,465.6	272,071,903.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,980,710.3	128,273,673.4
120	Нийтлэг татварын бус орлого	14,980,710.3	128,273,673.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	116,288,755.3	143,798,229.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	103,085,450.7	143,430,850.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,085,450.7	143,430,850.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,483,246.8	121,826,451.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,426,372.0	72,256,045.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,982,067.4	8,948,725.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,070,707.4	5,232,820.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,439,345.1	1,805,330.2
2105	Нормативт зардал	1,983,885.9	2,367,386.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,294,212.0	1,539,405.0
2107	Томилолт, зочны зардал	450,140.5	622,838.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,905,834.9	3,151,441.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,930,681.6	25,902,458.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,602,203.9	21,604,398.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	28,184,014.8	128,641,053.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22,961,339.7	10,755,124.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,222,675.2	117,885,928.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	ЗГ-ын оруулсан капитал	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,491,824.4	190,076,321.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	154,460.4	89,519.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,646,284.8	190,165,841.1
9	Тайлант үеийн үр дүн	-	5,222,675.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,646,284.8	195,388,516.3
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,764.0)	(69,722.2)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,641,520.8	195,318,794.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	23,930.4	23,930.4
19	Тайлант үеийн үр дүн	-	117,885,928.7
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,665,451.2	313,228,653.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	139,601,688.0	161,381,625.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,227,496.7	16,991,087.9
120	Нийтлэг татварын бус орлого	23,227,496.7	16,991,087.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	116,374,191.3	144,390,537.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,221,998.0	130,794,049.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,221,998.0	130,794,049.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,889,656.2	107,589,036.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,304,618.7	71,915,485.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,052,024.9	9,220,018.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,096,779.2	5,277,566.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,156,541.6	1,273,006.0
2105	Нормативт зардал	2,086,684.5	2,571,124.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,799,131.7	7,358,621.1
2107	Томилолт, зочны зардал	450,611.6	623,197.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,002,544.4	4,941,663.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,940,719.5	4,408,354.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,332,341.8	23,205,013.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	53,379,690.0	30,587,575.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	35,906,137.3	37,252,750.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,906,137.3	37,252,750.4
2200	Дотоод эх үүсвэрээр	35,906,137.3	37,252,750.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(35,906,137.3)	(37,252,750.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	17,473,552.7	(6,665,174.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,953,891.1	19,427,443.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,427,443.8	12,762,269.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,724,948,800.00	130,237,401,063.23	20,487,547,736.77	86.4
УРСГАЛ ЗАРДАЛ	135,439,748,800.00	116,850,449,135.23	18,589,299,664.77	86.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	118,352,471,200.00	107,402,072,067.67	10,950,399,132.33	90.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,676,503,600.00	71,541,816,710.46	7,134,686,889.54	90.9
Үндсэн цалин	35,167,623,200.00	31,696,366,042.66	3,471,257,157.34	90.1
Нэмэгдэл	22,150,765,000.00	21,035,504,948.10	1,115,260,051.90	95.0
Унаа хоолны хөнгөлөлт	10,603,052,000.00	9,848,234,434.52	754,817,565.48	92.9
Урамшуулал	10,755,063,400.00	8,961,711,285.18	1,793,352,114.82	83.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,830,174,300.00	9,178,172,659.70	652,001,640.30	93.4
Тэтгэврийн даатгал	6,434,308,800.00	6,056,568,847.38	377,739,952.62	94.1
Тэтгэмжийн даатгал	1,246,781,700.00	1,092,907,774.92	153,873,925.08	87.7
ҮОМШӨ-ний даатгал	549,967,000.00	488,499,422.68	61,467,577.32	88.8
Ажилгүйдлийн даатгал	354,276,300.00	305,080,000.02	49,196,299.98	86.1
Эрүүл мэндийн даатгал	1,244,840,500.00	1,235,116,614.70	9,723,885.30	99.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,623,185,500.00	5,277,566,454.63	1,345,619,045.37	79.7
Гэрэл, цахилгаан	2,742,315,600.00	2,048,101,655.12	694,213,944.88	74.7
Түлш, халаалт	3,215,686,600.00	2,693,306,996.27	522,379,603.73	83.8
Цэвэр, бохир ус	556,940,000.00	461,606,203.24	95,333,796.76	82.9
Байрны түрээс	108,243,300.00	74,551,600.00	33,691,700.00	68.9
Хангамж, бараа материалын зардал	1,335,636,300.00	1,269,824,223.13	65,812,076.87	95.1
Бичиг хэрэг	213,496,300.00	208,995,045.00	4,501,255.00	97.9
Тээвэр, шатахуун	588,800,000.00	559,796,585.00	29,003,415.00	95.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,750,000.00	70,462,783.13	12,287,216.87	85.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,220,000.00	35,743,068.00	3,476,932.00	91.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	411,370,000.00	394,826,742.00	16,543,258.00	96.0
Нормативт зардал	2,817,746,300.00	2,571,124,584.82	246,621,715.18	91.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	746,627,000.00	724,344,906.00	22,282,094.00	97.0
Хоол, хүнс	173,170,800.00	160,828,978.82	12,341,821.18	92.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,897,948,500.00	1,685,950,700.00	211,997,800.00	88.8
Эд хогшил, урсгал засварын зардал	9,900,727,800.00	9,225,688,054.50	675,039,745.50	93.2
Багаж, техник, хэрэгсэл	4,817,646,700.00	4,545,656,499.00	271,990,201.00	94.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	66,500,000.00	58,712,651.00	7,787,349.00	88.3
Урсгал засвар	5,016,581,100.00	4,621,318,904.50	395,262,195.50	92.1
Томилолт, зочны зардал	733,719,200.00	544,727,740.88	188,991,459.12	74.2
Гадаад албан томилолт	273,823,200.00	173,949,305.88	99,873,894.12	63.5
Дотоод албан томилолт	459,896,000.00	370,778,435.00	89,117,565.00	80.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,512,090,400.00	4,957,800,384.82	554,290,015.18	89.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,912,801,900.00	2,616,516,228.63	296,285,671.37	89.8

Гаалийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

үйлчилгээний төлбөр хураамж				
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,713,100.00	15,720,000.00	8,993,100.00	63.6
Даатгалын үйлчилгээ	152,554,000.00	84,673,359.43	67,880,640.57	55.5
Тээврийн хэрэгслийн татвар	12,044,100.00	8,754,264.00	3,289,836.00	72.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,551,400.00	2,383,000.00	1,168,400.00	67.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,274,952,200.00	1,134,827,459.76	140,124,740.24	89.0
Газрын төлбөр	29,515,800.00	21,995,473.00	7,520,327.00	74.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,101,957,900.00	1,072,930,600.00	29,027,300.00	97.4
Бараа үйлчилгээний бусад зардал	2,922,687,800.00	2,835,351,254.73	87,336,545.27	97.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,748,107,300.00	2,705,812,864.73	42,294,435.27	98.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	174,580,500.00	129,538,390.00	45,042,110.00	74.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,087,277,600.00	9,448,377,067.56	7,638,900,532.44	55.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	109,372,200.00	98,716,190.67	10,656,009.33	90.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	109,372,200.00	98,716,190.67	10,656,009.33	90.3
Бусад урсгал шилжүүлэг	16,977,905,400.00	9,349,660,876.89	7,628,244,523.11	55.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	67,095,000.00	(67,095,000.00)	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,126,774,000.00	1,754,675,121.09	1,372,098,878.91	56.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,547,021,400.00	7,364,218,855.80	6,182,802,544.20	54.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	304,110,000.00	163,671,900.00	140,438,100.00	53.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,285,200,000.00	13,386,951,928.00	1,898,248,910.00	87.6
Барилга байгууламж	785,200,000.00	770,196,838.00	15,003,162.00	98.1
Тоног төхөөрөмж	14,500,000.00	12,616,755,090.00	1,883,244,940.00	87.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150,724,948,800.00	130,239,429,863.23	20,485,518,936.77	100.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	146,479,241,600.00	125,810,799,791.69	20,668,441,808.31	100.1
Улсын төсвөөс санхүүжих	146,479,241,600.00	125,810,799,791.69	(195,412,616.69)	100.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,245,707,200.00	4,428,630,071.54	(182,922,871.54)	104.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,245,707,200.00	4,428,630,071.54	(182,922,871.54)	104.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,763,400.70	(3,763,400.70)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,792,200.70	(5,792,200.70)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	4,934	4,064	870	82.4
АЖИЛЛАГСДЫН ТОО	2,466	2,031	435	82.4
Удирдах ажилтан	44	44	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,895	1,490	405	78.6
Үйлчлэх ажилтан	527	497	30	94.3
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2,466	2,031	435	82.4

Гаалийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1,932	1,534	398	79.4
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	534	497	37	93.1

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,874,946,246.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,874,946,246.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,027,163,396.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	373,668,661.59
210101	Үндсэн цалин	-	47,695,679.38
210102	Нэмэгдэл	-	94,480,185.92
210104	Урамшуулал	-	231,492,796.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	41,845,428.38
210201	Тэтгэврийн даатгал	-	31,470,850.32
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,224,086.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,363,898.32
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,594,235.66
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,192,357.26
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,181,800.00
210402	Тээвэр, шатахуун	-	625,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,556,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	518,477,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	518,477,900.00
2107	Томилолт, зочны зардал	-	78,469,607.00
210701	Гадаад албан томилолт	-	78,469,607.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,520,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	11,520,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	847,782,849.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	38,960,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	38,960,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	808,822,849.32
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	808,822,849.32
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,874,946,246.29
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,874,946,246.29
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	528,466,549.29
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	32,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,313,979,697.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Гаалийн байгууллагад нийт 4,879.7 сая төгрөгийн 53 алдаа¹ илэрснээс аудитын явцад 4,831.6 сая төгрөгийн 50 алдааг залруулж, 48.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 919.0 сая төгрөгийн 33 зөрчил² илэрснээс, 11.7 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоож, 129.9 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 775.1 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж, 2.3 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 967.1 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 468.1 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 22 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллагад /Өөрчлөлтгүй/ дүгнэлт гаргаж, 7 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлээ.

3.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,831.6 сая төгрөгийн 50 алдаа, 967.1 сая төгрөгийн 36 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 11.8 сая төгрөгийн 9 зөрчил илэрсэн. Үүнээс санхүүгийн тайлангийн түвшинд илэрсэн зөрчил нь өмнөх оноос 409.6 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4. "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1-т Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, алдаа, зөрчлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил 409.6 сая төгрөгөөр нэмэгдсэн тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3.2 Түүврийн байгууллага

Гаалийн ерөнхий газрын Аж ахуй, үйлчилгээний алба нь тайлант онд худалдан авсан 89.5 сая төгрөгийн зөөврийн хард, рам зэрэг материалыг орлогод аван шууд зардлаар бүртгснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 777.1 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 67.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 709.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

3.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс нь төсөвт төлөвлөөгүй өөрийн чиг үүрэгт хамааралгүй хурал, зөвлөгөөн зохион байгуулахад зориулж 50.0 сая төгрөгийн зардлыг гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3.үр ашигтай байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Гаалийн ерөнхий газрын Аж ахуй, үйлчилгээний алба нь орон нутгийн томилолтын шатахууны зардлыг олгохдоо Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан жишиг нормын дагуу тооцоолоогүй 17.2 сая төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөлттэй холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын туслах үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг бодитой, үнэн зөв төлөвлөөгүйгээс орлого 709.9 сая төгрөгөөр буюу 21.0 хувиар давсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1.6-д "Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой тооцож төсөвт тусгуулах ба хэрэв үндэслэлгүй төлөвлөгөө батлуулсан нь нотлогдвол энэ журамд заасан зарцуулах эрх олгохгүй.", 3.1-д "Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасан, төсөвт байгууллагын төсвийн жилийн эхнээс өссөн дүнгээр тооцож гаргасан дараах орлогыг тооцно", 3.1.1-д "төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого", 3.2-т "Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан орлогыг энэ журмын гуравдугаар хавсралтад заасан үйл ажиллагаанаас олсон орлогын хүрээнд хамааруулж үзнэ", 3.6-д "энэ журмын 3.1.1-т заасан орлогын сүүлийн гурван жилийн гүйцэтгэл болон 3.1.2-т заасан орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төсөвт төвлөрүүлэх туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харахад 55.0 хувиар давсан байгаа тул тооцоо судалгаанд үндэслэн туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөх.

2. Өмчийн ашиглалттай холбоотой

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн шатахуун, жолоочийн замын хуудас, ашиглалтын тооцоо болон зогсоолын бүртгэлийг тулган шалгахад тус тээврийн хэрэгслүүдтэй холбоотой зарцуулалт гараагүй, харьяа байгууллагуудад ашиглагдаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн "Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх: 1-т /өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ашиглалт хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 11.9 сая төгрөгийн 9 зөрчил илэрснээс 7.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 4.4 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Илрүүлэлт: БНХАУ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон Гашуунсухайт боомтын барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсан боловч Монгол Улсын хилийн тухай болон Гаалийн тухай хуулиудын давхардсан заалтуудаас шалтгаалан тус хөрөнгийг данс бүртгэлд авах байгууллага тодорхойгүйгээс Гаалийн ерөнхий газрын санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолын 4.4.-т " Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана.", Монгол улсын Хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн "29.9-т Ашигт малтмал, газрын тос, бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, улс хоорондын тээврийн зохицуулалт, халдвар хамгаалал, хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог нэгдсэн зохицуулалтаар хангах, боомтын хөгжлийн асуудлыг төлөвлөх, орон сууц, цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус болон бусад дэд бүтцийг хариуцаж, боомтын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хилийн боомт дахь төрийн өмчийн бүртгэл, хяналтыг хариуцах чиг үүрэг бүхий Хилийн боомтын захиргааг Засгийн газар байгуулна.", Гаалийн тухай хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1.1.10-т "хилийн боомтын барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцан зохион байгуулах, хилийн хяналтын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламжийг данс бүртгэлд тусгах асуудлыг Хилийн боомтын захиргаа болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн шийдвэрлэх.

4.2 Түүврийн байгууллага

Илрүүлэлт: Тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой ажил гүйлгээний холбогдох баримт материалд нийлүүлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтны тамга, гарын үсгийн сканердсан хувилбарыг ашиглаж байгаад хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т "Энгийн хэлбэртэй бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудын бүрдэлд тавих хяналтыг сайжруулах.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гашуунсүхайд дахь ГГ	2	18,485.0	2	18,485.0	-	-	2	18,485.0	-	-	-	-
Говь-Алтай аймгийн Бургастай дахь ГХ	3	15,693.3	1	355.0	2	15,338.3	3	15,693.3	-	-	-	-
Замын-Үүд дахь ГГ	1	2,000.0	-	-	1	2,000.0	1	2,000.0	-	-	-	-
Орхон аймаг дахь ГГ	5	300,089.6	3	293,810.7	2	6,278.9	5	300,089.6	-	-	-	-
Сүхбаатар аймгийн Бичигт дэх ГГ	2	346.7	-	-	2	346.7	2	346.7	-	-	-	-
Сайншанд дахь ГГ	1	9,032.4	1	9,032.4	-	-	1	9,032.4	-	-	-	-
Сэлэнгэ аймаг дахь ГГ	1	1,925.0	-	-	1	1,925.0	-	-	1	1,925.0	1	1,925.0
Увс аймаг дахь ГГ	1	55,252.6	1	55,252.6	-	-	1	55,252.6	-	-	-	-
УБ хот дахь ГГ	7	1,268,885.7	4	1,249,484.9	3	19,400.8	6	1,268,885.7	1	-	1	-
УХШИГГ	12	531,919.9	1	1,629.8	11	530,290.1	12	531,919.9	-	-	-	-
Ховд аймгийн Булган дахь ГГ	1	250.8	-	-	1	250.8	1	250.8	-	-	-	-
Ханги дахь ГГ	5	2,119,810.9	4	2,105,363.5	1	14,447.4	5	2,119,810.9	-	-	-	-
Шивээхүрэн гаалийн газар	6	195,516.7	6	195,516.7	-	-	6	195,516.7	-	-	-	-
Чингис хаан ОУ-ын нисэх буудлын ГГ	5	270,909.5	2	82,607.3	3	188,302.2	4	224,746.5	1	46,163.0	1	46,163.0
Харъяа байгууллагын дүн	52	4,790,118.1	25	4,011,537.9	27	778,580.2	49	4,742,030.1	3	48,088.0	3	48,088.0
Түүврийн байгууллага												
Аж ахуй, үйлчилгээний алба	1	89,539.6	-	-	1	89,539.6	1	89,539.6	-	-	-	-
Нийт дүн	53	4,879,657.7	25	4,011,537.9	28	868,119.8	50	4,831,569.7	3	48,088.0	3	48,088.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баян-Өлгий аймаг дахь ГГ	1	6,712.5	-	-	1	6,712.5	-	-	-	-	-	-
Гашуунсухайт дахь ГГ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Говь-Алтай аймгийн Бургастай дахь ГХ	1	8,031.3	-	-	1	8,031.3	-	-	-	-	-	-
Дархан-Уул аймаг дахь ГГ	1	644.6	1	644.6	-	-	-	-	-	-	-	-
Дорнод аймаг дахь ГГ	2	59,843.2	-	-	1	295.7	1	59,547.5	-	-	-	-
Замын-Үүд дэх ГГ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Орхон аймаг дахь ГГ	9	20,502.5	6	7,953.4	2	7,591.7	1	4,957.4	-	-	-	-
Сүхбаатар аймгийн Бичигт дэх ГГ	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-
Сэлэнгэ аймаг дахь ГГ	2	37,417.2	-	-	2	37,417.2	-	-	-	-	-	-
Ув хот дахь ГГ	1	2,314.0	-	-	-	-	-	-	1	2,314.0	-	-
УХШИГГ	1	2,642.6	-	-	1	2,642.6	-	-	-	-	-	-
Ховд аймгийн Булган дахь ГГ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Хөвсгөл аймаг дахь ГГ	1	3,126.8	1	3,126.8	-	-	-	-	-	-	-	-
Шивээхүрэн дэх ГГ	3	-	-	-	-	-	3	-	-	-	-	-
Чингис хаан гаалийн газар	2	668.3	-	-	-	-	2	668.3	-	-	-	-
Харъяа байгууллагын дүн	29	141,903.0	8	11,724.8	8	62,691.0	12	65,173.2	1	2,314.0	-	-
Түүврийн байгууллага												
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	2	759,950.0	-	-	1	50,000.0	1	709,950.0	-	-	-	-
Аж ахуй, үйлчилгээний алба	2	17,191.7	-	-	1	17,191.7	1	-	-	-	-	-
Нийт дүн	33	919,044.7	8	11,724.8	10	129,882.7	14	775,123.2	1	2,314.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Гашуунсухайт дахь ГГ	1	-	-	-	-	-	1	-
ДарханУул аймаг дахь ГГ	1	-	-	-	1	-	-	-
Орхон аймаг дахь ГГ	1	-	-	-	-	-	1	-
Сүхбаатар аймгийн Бичигт дэх ГГ	1	-	-	-	-	-	1	-
Сайншанд дахь ГГ	1	-	-	-	1	-	-	-
Дүн	5	-	-	-	2	-	3	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шивээ хүрэн дэх ГГ	2	4,381.0	-	-	-	-	2	4,381.0
УХШИГГ	1	7,748.4	-	-	1	7,480.4	-	-
Харъяа байгууллагуудын дүн	8	11,861.4	-	-	3	7,480.4	5	4,381.0
Түүврийн байгууллага								
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	9	11,861.4	-	-	3	7,480.4	6	4,381.0